



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын “Илчит хутаг” ОНӨХХК-ий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/08/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас:9907-9641 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

№ 2026.09.17 № 326
танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН "ИЛЧИТ
ХУТАГ" ОНӨХХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.АТАРСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Илчит хутаг" ОНӨХХК-ий 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Илчит хутаг" ОНӨХХК-ий 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв топиуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- ✘ Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 07/26 дугаар албан бичгээр хугацаа хоцроож ирүүлсэн,
- ✘ "ЦЭСБ аудит" ХХК-иар 2022-2024 оны үйл ажиллагаанд 5.0 сая төгрөгөөр хөндлөнгийн аудит хийлгэж төлөвлөгдөөгүй, үр ашиггүй зардал гаргасан, үйлдвэрлэлийн ослоор нас барсан нь тодорхойлогдоогүй албан хаагчдад нэг жилийн цалинтай тэнцэх хэмжээний 15.8 сая төгрөгийн тэтгэмж олгосон,
- ✘ Орлого үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оныг тайлагнаагүй, нүүрсний тооцоо болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгийг үнэн зөв тооцоогүй,
- ✘ Нийт 88 иргэн, хуулийн этгээдээс 42 иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулаагүй, ерөнхий журналд халаалтын орлогыг дутуу бүртгэсэн,
- ✘ Борлуулалтын орлогыг гэрээний дүнгээр авлага үүсгээгүй, дансны давхар бичилт (авлага-Дт) хийгээгүй ерөнхий журналд мөнгөн хөрөнгийн дансанд шууд бичилт хийж бүртгэсэн, өөрийн эзэмшлийн гзрыг сумын Засаг даргын Тамгын газартай ашиглалтын гэрээгүй эзэмшдэг,
- ✘ Цалин, нийгмийн даатгалтын шимтгэл, материал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг удирлагын зардалд бичилт хийж тайлагнасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч тархаагүй байна.

6326050492

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", тухайн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны 8 дугаар хуралдааны 55 дугаар тогтоолуудтай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд сумын Засаг дарга, "Үлэмж хүрд" ХХК-ий захиралтай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 185.0 сая төгрөгийн өртөг бүхий 2МВт иж бүрэн зуухны төлбөр тооцоог 6 удаа хувааж, 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр бүрэн төлж барадуулах нөхцлөөр худалдан авсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Тус компани өнөөдрийн байдлаар тарифын шинэчлэл, дэд бүтцийн санхүүжилт, машин техник шинэчлэх, бохир усны байгууламж өргөтгөл, нөөц цахилгаан үүсгүүр, хог тариф айлын хураамжид тулгамдаж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	44,735.5	91,730.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,490,395.8	3,634,088.9
	Нийт хөрөнгийн дүн	3,535,131.3	3,725,819.2
	Нийт өр төлбөрийн дүн	106,614.7	158,254.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,428,516.6	3,567,564.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,535,131.3	3,725,819.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	888,384.5	1,285,197.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,128,002.6	1,130,700.2
	Үйл ажиллагааны үр дүн	(239,618.1)	154,497.5
	орлогын албан татварын зардал	-	15,449.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(239,618.1)	139,047.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,668,134.7	3,428,516.6
	Тайлант оны үр дүн	(239,618.1)	139,047.8
	Эцсийн үлдэгдэл	3,428,516.6	3,567,564.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,922,784.2	3,220,718.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,879,446.8	3,196,065.4
	Үйл ажиллагааны ЦМГ	43,337.4	24,652.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(43,337.4)	(24,652.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	988,367.6
	Урсгал зардал	-	988,367.6
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	985,830.2
	Улсын төсвөөс санхүүжих	-	985,830.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Илчит хутаг” ОНӨХХК-ий эрхэм зорилгоо “Хутаг-Өндөр сумын иргэдэд найдвартай, тасралтгүй, хүртээмжтэй дэд бүтцийн үйлчилгээ үзүүлж, орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах” гэж тодорхойлжээ.

Тайлант онд алдагдлаас гарах, дэд бүтэц шинэчлэх, орлого нэмэгдүүлэх, машин техник шинэчлэх, боловсон хүчнийг бэхжүүлэх гэсэн 5 зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны дараах чиглэлийг заасан байна. Үүнд:

1. Дулаан үйлдвэрлэл, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, хот суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ,
2. Цэвэр болон бохир ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ,
3. Ус түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээ, бохир усны гаргалгааны, цуглуулах, татан зайлуулах, шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ,
4. Халуун ус, саун, хувцас угаалгын үйлчилгээ, барилгын гадна, дотор засал, орчны тохижилтын үйлчилгээ, нийтийн эзэмшлийн зам талбай, суваг шуудай, гэрэлтүүлгийн засвар, ашиглалт,
5. Хог хаягдал ангилан ялгах, татан зайлуулах, дарж булшлах, хоёрдогч түүхий эд бэлтгэн нийлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
6. Нийтийн эзэмшлийн цэцэрлэгжүүлэлт, ойжуулалт, ногоон байгууламжийн тохижилт, засвар үйлчилгээ,
7. Үндсэн үйл ажиллагааны өртөг, зардлыг бууруулах, хөрөнгө санхүүжилтийг нэмэгдүүлэх гадна дотно төсөл хөтөлбөрөөс буцалтгүй тусламж, санхүүжилт татах, зээл авах, эргэн төлөх,
8. Хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн зах зээлийн харилцаанд оролцож хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх,
9. Компаний хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагааны чанар үр өгөөжийг алдагдуулахгүй, тохиолдолд эрхлэх шийдвэрийг ТУЗ-өөр, Урт хугацаат үр ашгаа өгөх, үндсэн үйл ажиллагаанд санхүүгийн ямар нэгэн хүндрэл учруулах эрсдэл үүсэх шинжтэй бол ИТХ-аар батлуулах явуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ус, дулаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, зам талбай, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Илчит хутаг” ОНӨХХК нь сумын ИТХ-ын 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй... 2/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сумын засаг дарга томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-д “ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох” гэсэн заалттай нийцэж байна.

“Илчит хутаг” ОНӨХХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг жилийн 0.2 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын Засаг дарга, Үлэмж хүрд ХХК-ий захиралтай 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдөр 185.0 сая төгрөгийн өртөг бүхий 2МВт иж бүрэн зуухны төлбөр тооцоог 6 удаа хувааж, 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр бүрэн төлж барадуулах нөхцлөөр худалдан авсан байна.

Тав. Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тавих 116 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна. Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт

хэмнэлтийн шалтгаан, тайлбар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг болон хоёр мэдээлэл дутуу хангалтгүй мэдээлсэн, өссөн дүнгээр мэдээлээгүй, хавсралт файл болон нотлох баримтыг оруулаагүй худал, чанаргүй мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хутаг-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 7 гишүүний орон тоотойгоор шинэчлэн байгуулагдсан байна. ТУЗ-ийн 2 гишүүн Компаний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасан компаний засаглалын сургалтад хамрагдсан байна.

Үндсэн түүхий эд материал болох нүүрсийг нэг тн тутмын үнийг 45.0-115.0 мянган төгрөгийн 6 өөр үнээр харилцан адилгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Иймд ТУЗ-ийн гишүүдийг чадавхжуулах, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, нүүрсний үнийн худалдан авалт, үйлдвэрлэлд ашиглалтгүй, хөдөлгөөн өөрчлөлт хийгдээгүй хангамжийн материалд горим сорил хэрэгжүүлэх нь үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 15.4 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 15.4 сая төгрөгийн 1 алдааг бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 2,371.8 сая төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 2,372.0 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 429.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2,371.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 11.3 сая төгрөгийн түвшнээс 2,360.5 сая төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Залруулсан алдаа

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулга хийгдээгүй болно.

Төлбөрийн акт

Төлбөрийн актыг тогтоогдоогүй.

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Борлуулалтын орлогыг гэрээний дүнгээр авлага үүсгээгүй, 42 иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулаагүй, үйлдвэрлэлийн ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, түүхий эд материал, нүүрс, шатахуун, сэлбэгийн зардлын нийт 1,921.1 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй, дансны давхар бичилтийн системээр бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-2 Бараа материал, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал "Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэн албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Үйлдвэрлэлийн ослоор нас барсан гэх хангалттай нотлох баримтгүйгээр нэг албан хаагчид жилийн цалинтай тэнцэх хэмжээний 15.8 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нотлох баримтын шаардлага хангаагүй тэтгэмж олгодог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 3: Булган аймаг дахь Төрийн аудитын байгууллагын гаргасан дүгнэлтийг шалгуулахаар "ЦЭСБ аудит" ХХК-иар 2022-2024 оны үйл ажиллагаанд 5.0 сая төгрөгөөр хөндлөнгийн аудит хийлгэж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр ашиггүй зардал гаргаж хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр аудитын дүгнэлтийг дахин давтан гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 4: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 07/26 дугаар албан бичгээр Булган аймаг дахь Төрийн аудитын газар хугацаа хоцроож ирүүлсэн, шилэн дансны цахим хуудсанд тавих 116 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл хугацаа

хоцроож, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, хуулиар хүлээсэн албан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Илчит хутаг" ОНӨХХК-ий гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Орлого үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оныг тайлагнаагүй, нүүрсний тооцоо болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үнэн зөв тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар зүйл, ТӨБЗГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам" 2019 оны 271 дүгээр тогтоол, Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны 8 дугаар хуралдааны 55 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэлийн ажилчдын цалин, үйлдвэрлэлд ашиглагдах бусад материал зэрэг шууд хөдөлмөрийн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг ББӨ-д үнэн зөв хуваарилж, удирдлагын зардлыг бууруулж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татвар төлөхийн өмнөх ашиг 154.5 сая төгрөгийн ашигтай байхад албан татварын зардал тооцож тайлагнаагүй.	1	15			1	15.4						
Дүн	1	15			1	15.4						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д/д	Алдаа зөрчлийн утга	Үүнээс										Зөвлөмж	
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Заглуулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар													
1	Борлуулалтын орлогыг гэрээний дүнгээр авлага үүсгээгүй, 42 иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулаагүй, үйлдвэрлэлийн ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, түүхий эд материал, нүүрс, шатахуун, сэлбэгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, дансны давхар бичилтийн системээр бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан байна.	1	1,921.1					1	1,921.1				
2	Үйлдвэрлэлийн ослоор нас барсан гэх хангалттай нотлох баримтгүйгээр нэг албан хаагчид жилийн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон байна.	1	15.8					1	15.8				
3	Булган аймаг дахь Төрийн аудитын байгууллагын гаргасан дүгнэлтийг шалгуулахаар "ЦЭСБ аудит" ХХК-иар 2022-2024 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж, үр ашгийг зардал гаргасан байна.	1	5.0					1	5.0				

4	Орлого үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оныг тайлагнаагүй, нүүрсний тооцоо болон борлуулсан бүтээгдэхүүний ертгийг үнэн зөв тооцоогүй.	1	429.9										1	429.9		
	ДҮН	4	2,371.8										3	1,941.9	1	429.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал

1	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 07/26 дугаар албан бичгээр Булган аймаг дахь Төрийн аудитын газар хугацаа хоцроож ирүүлсэн, шилэн дансны цахим хуудсанд тавих 116 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.	1	-										1	-	-	-	
	Дүн	1	-										3	1,941.9	1	-	429.9
	НИЙТ ДҮН	5	2,372										3	1,941.9	1	-	429.9